



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/134

Есөнбулаг

Тусгай зөвшөөрөл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундааны худалдаанд тавигдах шаардлагыг хангаж, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл авахаар материалаа ирүүлсэн аж ахуйн нэгжүүдэд согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийг хавсралтаар олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомж, шаардлага журмыг зөрчсөн тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газар (Н.Мэндбаяр), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын 02-ны өдрийн 1/дугаар  
захирамжийн хавсралт



СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
ОЛГОСОН АЖ АХУЙН НЭГЖҮҮД

Д/д	Сумын харьяалал	Аж ахуйн нэгжийн нэр	Дэлгүүр, үйлчилгээний газрын нэр	Байрлал	Худалдаа үйлчилгээний хэлбэр
1.	Бигэр сум	Алтантөвш хоршоо	8 нэрийн хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
2.	Есөнбулаг сум	Гэрэлт есөн цалиг ХХК	Өрнөн-Ундрах хүнсний дэлгүүр	Индэрт баг	Худалдах
3.	Есөнбулаг сум	Ундрагын эх ХХК	Баянхутаг хүнсний дэлгүүр	Жинст баг	Худалдах
4.	Есөнбулаг сум	Буудайн хөх уулс ХХК	Хантайширын Оргил бөөний төв	Жаргалант баг	Худалдах
5.	Есөнбулаг сум	Өгөөмөр Баян-Алтай ХХК	Баян-Алтай хүнсний дэлгүүр	Түмэн баг	Худалдах
6.	Жаргалан сум	Зэл мод хоршоо	Хүлэг хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
7.	Цогт сумын Баянтоорой тосгон	Шугуйн зам ХХК	Булган хайрхан хүнсний дэлгүүр	Тосгоны төв	Худалдах
8.	Халиун сум	Унаган хүрэн ХХК	Ундрал хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах

